

ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА

ДЭЛХИЙН ХОТЖИЛТ, ХҮН АМЫН БОДЛОГЫН АСУУДАЛД

Д.Тунгалаг*

2008 онд дэлхийн түүхэнд анх удаа хүн төрөлхтний талаас илүү буюу 3.3 тэрбум хүн хот суурин газар амьдрах болно. Энэ тоо 2030 он гэхэд ойролцоогоор 5 тэрбумд хүрч нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа Африк, Азийн хотын хүн ам 2000-2030 оны хооронд хоёр дахин өсөх магадлал бий бөгөөд хотын иргэдийн олонх ядуу байх болно. Тэрхүү өсөлтийг урьдчилан харж, бэлтгэх зорилгоор өнөөдөр бидний гаргасан шийдвэрээс хотын ядуучууд, хөгжиж буй орнуудын хотууд, түүнчлэн хүн төрөлхтний ирээдүй ихээхэн хамаарах билээ.

Эх сурвалж: НҮБ-ын хүн амын сангийн "Дэлхийн хүн амын байдал- 2007" тайлан илтгэлээс

Дэлхийн улс орнуудад хүн ам зүйн үзэгдэл янз бүрийн байдлаар илэрч байгаа ба хөгжиж буй орнуудын хувьд онцгой хурцадмал байдалтай байгаа нь хүн амын тооны түргэн өсөлт, хотжилтын үйл ажиллагаатай шууд холбоотой юм. Хотжилт нь хот, суурин газрын хүн амын тооны эрс өсөлтийн хандлагаар тодорхойлогдох болсон XX зууны нэлээд том өөрчлөлтүүдийн нэг болоод байна.

1900 онд дэлхийн хүн ам 1,7 тэрбум байсан ба түүний 13 хувь нь хот, хот маягийн суурин газруудад амьдарч байжээ. Харин 2000 он гэхэд дэлхийн хүн ам 6,2 тэрбумд хүрч 48 хувь нь хотод амьдарч байна гэсэн тооцоо гарчээ. Эндээс XX зуунд зөвхөн хот маягийн суурин газарт амьдрагчдын хувь өсөөд зогсохгүй, хотод амьдрагчдын тоо 1900 онд 220 сая байснаа 2000 онд 2,9 тэрбум болтлоо өссөн нь харагдаж байна. XXI зуунд энэ хандлага улам өссөөр байх нь тодорхой.

Хотын хүн амын эрс өсөлтөд дараах 3 хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд:

- а) хот суурин газрын хүн амын цэвэр өсөлт;
- б) хот руу бөөн бөөнөөрөө шилжих хөдөлгөөн;
- в) хөдөө тосгон хот маягийн суурин газар болж өөрчлөгдсөөр байгаа зэрэг болно.

* МУИС, ОУХС-ийн профессор, доктор

Хүн амын бодлого гэдэг нь хүн ам зүйн үзэгдэл, үйл явдлыг төрөөс зохицуулах үйл ажиллагаа билээ. Хэдийгээр зарим олон улсын байгууллагууд өрх төлөвлөлтийн туршлагыг социалист гэгдэж байсан орнуудад, тухайлбал ОХУ-д туршиж үзсэн боловч практик ач холбогдлоо өгч чадаагүй юм.

Хүн амын бодлого бол хөгжиж буй орнуудын хүн амын түргэн өсөлттэй шууд холбоотой нь ойлгомжтой. Иймээс зөв бодлого явуулах нь хоцрогдсон үйлдвэрлэх хүчинтэй, хүн амын дийлэнх нь ядуу, байгалийн нөөц багатай, хүн ам шигүү суурьшсан улс орнуудад амьдралын зайлшгүй чухал асуудал болоод байна.

БНХАУ, Энэтхэг зэрэг орнуудад өрх төлөвлөлтийн салбарт нэлээд хатуу гэж хэлж болохоор хүн амын төрөлтийг хязгаарлах бодлого явуулж байгаа нь тохиолдлын асуудал биш билээ. Тухайлбал БНХАУ-д л гэхэд нэг өрх нэг хүүхэдтэй байх бодлого явуулсны үр дагавар өнөөдөр хүйсийн тэгш бус байдалд хүргэж улмаар жирэмсэн байх хугацаанд хүйс тодорхойлохыг хориглосон арга хэмжээ авахад хүргээд байна. Үр удмаа үлдээхийн тулд эрэгтэй хүүхэд төрүүлэх сонирхлоос улбаалж хүйсийн харьцаа алдагдаж улмаар нийгмийн хурц эсэргүүцэлтэй тулгарах боллоо. Иймээс сүүлийн жилүүдэд энэ асуудал НҮБ-ын үйл ажиллагаанд нэлээд чухал байр суурь эзлэх болов.

Харин хөгжингүй орнуудын хүн амын бодлого эрс өөр, тухайлбал эдгээр орнуудад хүн амын өсөлт буурах хандлага ажиглагдах болсон нь санаа зовох асуудлын нэг болж байна. Европын зарим орнуудын засгийн газар, тухайлбал Франц улсад л гэхэд төрөлтийг ихэсгэх талаар тодорхой арга хэмжээ авч байгаа боловч практик үр дүн гарахгүй байна. Хүн амын дийлэнх нь амьдрах болсон хот суурин газруудын өсөн нэмэгдэж байгаа ачаалал, нийгмийн даралт, бүх төрлийн хөдөлмөрийн идэвхжилт, зах зээл болон хүмүүсийн амьдралд шинээр гарч ирж буй хэрэгцээ зэрэг хүчин зүйлүүд өрхийн тоог нэмэгдүүлэх, төрөлтийг хурдасгахад зайлшгүй нөлөөлөх учиртай. Мөн хөгжингүй орнуудын нийгмийн хөгшрөлт явагдах зүй тогтол ажиглагдаж байна. Энэ бүхнээс ирээдүйд яах вэ гэдэг асуудал зайлшгүй урган гарч байгаа юм.

Хүн амын бодлого өргөн утгаараа хүн амын өсөлтийг хянахад чиглэгдсэн арга хэмжээ, түүнчлэн хүн амын төрөлтөд хяналт тавих хөтөлбөр, өргөн сурталчилгаа, маркетинг, жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг тараах, сайн дураар татгалзах зэрэг олон асуудлуудыг агуулдаг. Мөн гэрлэлтийн насны доод хязгаарыг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн эдийн засгийн статусыг өсгөх зэрэг арга хэмжээг байнга авсаар байна. Гэхдээ хүн амын талаарх хяналтын бодлогын хамгийн илүү ашигтай арга нь

амьжиргааны түвшинг дээшлүүлэх явдал бөгөөд хөгжингүй орнуудын туршлагаар орлого өсөхөд төрөлт багасдаг гэдэг нь батлагдсан юм.

Хотжилт нь нийт хүн амын дотор суурин хүн амын эзлэх хувиар тодорхойлогддог бөгөөд давуу тал, сул талтай, гэхдээ хотжилтыг дагалдах давуу тал сул талаас олон байдаг. Харин эдгээр давуу талыг хүнд хэрэгтэй байдлаар ашиглах нь тулгамдсан асуудал болж байна.

Өнөөгийн байдлаар дэлхийн хэмжээгээр хот суурин газарт ядуурал, ядуучуудын хороолол, нийгмийн тэгш бус байдал ихсэж байгаа хэдий ч аж үйлдвэр хөгжсөн улс орон болгон хотжилтын тусламжтайгаар эдийн засгаа өсгөдөг жамтай. Хот хэдийгээр ядуурлыг төвлөрүүлдэг ч нөгөө талаас ядуурлаас гарах хамгийн их бололцоотой орон зай юм. Түүнчлэн хот байгаль орчинд хөнөөл учруулдаг ч ядуурал, орон сууц, байгаль орчин, удирдлага зохион байгуулалтын гээд олон тулгамдсан асуудалтай тулгардаг. Хэдийгээр том хотууд үргэлж анхаарлын төвд байгаа боловч жижиг хот суурингийн хүн ам хамгийн ихээр өсөх төлөвтэй байна. Тэдний бололцоо чадавхийг бэхжүүлэх нь зайлшгүй чухал асуудал. Төр засгаас авч хэрэгжүүлэх бодлогын зөв арга хэмжээ нь хот суурингийн хүн амын өсөлтөөс үүдэн гарах нийгмийн, байгалийн, амьжиргааны нөхцлийг шийдвэрлэхэд чухал нөлөөтэй.

Хотжилт бол ямар нэгэн улсын хөгжлийн үндсэн том шалгууруудын нэг гэдгийг олон баримтаас харж болно. Хотжилтыг дагаад эдийн засгийн идэвхтэй орчин бүрдэж, худалдаа үйлдвэрлэл гэх мэт амин чухал баталгаат нийгмийн суурь тавигддаг. НҮБ-аас дэлхийн хотын хүн амын тоог тодорхойлох, хэтийн төлөвийг тооцож гаргахдаа юуны өмнө тодорхой хугацаанд гарсан хот, хөдөөгийн хүн амын өсөлтийн хурдын өөрчлөлтийг тодорхойлох үзүүлэлт болох улс бүрийн хот, хөдөөгийн хүн амын харьцааг авч үздэг.

НҮБ-ын Хүн амын сангийн “Дэлхийн хүн амын байдал - 2007” илтгэлд энэ байдлаас гарахад нэгдүгээрт, хотын хүн ам өсөхөд түүнд ядуу хүмүүсийн эзлэх хувь маш өндөр байна, хоёрдугаарт, шилжих хөдөлгөөнөөс илүүтэйгээр ердийн өсөлтөөс болж хотын хүн ам өснө гэсэн хоёр гол дүгнэлтийг гаргажээ.

Энэ хоёр дүгнэлттэй холбоотойгоор дараах бодлогыг авч хэрэгжүүлэхийг санал болгосон байна. Үүнд:

- шилжих хөдөлгөөнийг хорих замаар хотын өсөлтийг хязгаарлах гэсэн оролдлогыг зогсоох, ядуу хүмүүсийн хот суурин газарт амьдрах хүсэл сонирхлыг дэмжих,

- ядуурлыг бууруулж, тогтвортой байдлыг дэмжихийн тулд газрыг хэрхэн ашиглах талаар алсыг харсан, өргөн хүрээтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх,
- хотын ирээдүйд чиглэсэн үйл ажиллагааг одооноос эхлэн нийгмийн хөдөлгөөн, Засгийн газар, олон улсын байгууллагууд хамтран санаачилж, хэрэгжүүлэх зэрэг болно.

Дэлхийн хэмжээгээр хот суурингийн өсөлт XXI зууны хөгжилд нөлөөлөх хамгийн том хүчин зүйл болоод байна. Өнөөгийн хотжих үйл явц их өргөн хүрээтэй явагдаж байгаа бөгөөд хөгжиж буй улс орнуудад гол нь төвлөрч байгаа билээ. Тухайлбал 2000-2030 онд Азийн хот суурингийн хүн ам 1.36 тэрбумаас 2.64 тэрбум, Африкийнх 294 саяас 742 сая, Латин Америк, Карибийн бүсийнх 394 саяас 609 сая болж өснө гэсэн тооцоо гарчээ.

Мөн дэлхийн суурин хүн амын тал хувь нь 500 мянгаас доош хүнтэй хотод амьдарч байна гэсэн ч тооцоо байна. Хотын асуудлуудыг жижиг хотод шийдвэрлэхэд зарчмын хувьд хялбар байдаг боловч хүн хүч, санхүү болон техникийн нөөц багатай байдаг нь хүндрэл учруулдаг. Харин том хот суурин газрууд ядуурлыг бууруулах илүү их боломжтой байдаг. Гэвч шилжих хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор ядуучуудын асуудлыг шийдвэрлэхгүй орхиж, тэдний нөөц бололцоог тооцохгүй байгаагаас энэ давуу тал ашиглагдахгүй өнгөрч байна. Иймээс ч хөдөө орон нутгийг бодоход хот суурин газарт ядуурал илүү хурдацтай өсч байна. Дэлхий дээр өнөөдөр тэрбум орчим хүн ядуу амьдарч байгаа бөгөөд тэдний 90 гаруй хувь нь хөгжиж буй оронд байгаа нь дээрх асуудлыг баталж байгаа хэрэг.

Хотжилтын асуудлыг нааштайгаар шийдвэрлэхийн тулд дэлхийн байгаль орчны өөрчлөлттэй холбоотой цогц арга хэмжээ авах, далайн түвшин дээшилж байгаа өнөө үед хотын хүн амын 10 гаруй хувийг эзэлдэг эрэг хавийн бүс нутаг, далай, томхон нуур цөөрөм, голын эрэг дээр амьдарч байгаа хүмүүсийн хувь заяаг нааштайгаар шийдвэрлэх тодорхой арга хэмжээ авч эхлэх шаардлагатай болоод байна.

Хотжилт нь ядуурал, хүйсийн тэгш бус байдлыг бууруулах, тогтвортой хөгжлийг дэмжих зэрэг чухал боломжуудыг бий болгодог хэдий ч хүн амын тоо их хэмжээгээр нэмэгдэх төлөвтэйг анхааралдаа авч аливаа тулгамдсан асуудалд тодорхой хэмжээгээр бэлтгэлтэй байх нь бид бүхний анхаарлын төвд байх учиртай боллоо.

Дэлхийн олон улсын байгууллагууд өөрийн туслалцааг хөгжиж буй улс орнуудад үзүүлдэг бөгөөд хотжилттой холбоотой сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлсэн,

санаачлагатай арга хэмжээ авахыг анхааруулж байгаа билээ. Мөн хүн амын шилжих хөдөлгөөнийг хязгаарлах нь тэр бүр үр дүн өгөхгүй, харин ядуурлыг бууруулах, эмэгтэйчүүдийн эрхийг хангах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах замаар хотын өсөлтийг зохицуулж болох юм гэсэн дүгнэлт гарсан.

Өнөөдөр Монгол орны 3 саяд дөхөж буй ард түмний маань тал орчим хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Энэ тоо улам ихсэнэ. Гэтэл тэдний 40 гаруй хувь нь хотжоогүй хэвээрээ гэр хороололд амьдарч байгаа гэсэн тооцоо бий.

Хөдөө орон нутагт буй ажилгүйдэл, ядуурал нийслэл хотын ард иргэдийн тоог өдрөөс өдөрт өсөн нэмэгдүүлсээр байна. Энэ хирээр Монгол орны газар нутаг эзгүйрч хот гэдэг энэ их айлын жижигхэн суурин дээр хүн амын нягтрал улам бүр ихэссээр байна. Агаарын бохирдол, ядуурал, үнийн өсөлт, ажилгүйдэл, замын бөглөрөл, бухимдал,... Энэ байдлаас яаж гарах вэ гэдэг асуудал бидний өмнө тулгарч байна.

Дэлхийн цаг агаар урьд өмнө ажиглагдаж байгаагүйгээр хурдан өөрчлөгдөж байгаа энэ цаг үед өдөр бүр манай дэлхийн аль нэг хэсэгт байгалийн ямар нэгэн гамшиг тохиолдож байна. Хүний буруу үйл ажиллагаанаас болон өндөр хурдацтай явагдаж байгаа энэ үйл явц хэнд, хэзээ тохиолдохыг хэн ч хэлж мэдэхгүй бөгөөд монголчууд биднийг шууд болон шууд бусаар дайрах магадлал өдөр ирэх тусам ихэсч байгааг анхаарах цаг болжээ.